



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗАР**

321 дүгээр байр, Лувсанданзанжандангийн ергэн чөлөө 3  
туламж, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сүм,  
Баянхонгор аймаг, 64101

Утас: (976) 70444469

Цахим шуудан: Sankhuyaltdt.bkh.gov.mn

Цахим хаяг: www.sankhuy.bkh.gov.mn

2026.01.30 № 06/12  
Танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ**

Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний төрийн  
болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2025  
оны 04 дүгээр улирлын Шилэн дансны мэдээлэлд  
хийсэн хяналт шалгалтын танилцуулгыг хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.  
Хавсралт *12* хуудастай.

ДАРГА *ММВ* ГЭЖРАЛЦЭЦЭГ



642503194

D:/2026 on-aiBa-A5-2026.docx/





**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗАР  
ТАНИЛЦУУЛГА**

321 дүгээр байр, Лувсанданзанжанцангийн өргөн  
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70444469  
Цахим шуудан: Sankhuuaudit.bkh.gov.mn  
Цахим хаяг: www.sankhuu.bkh.gov.mn

2026.01.30 № 08/03

Г СУМДЫН ЗАСАГ ДАРГА, САНХҮҮГИЙН  
АЛБАНЫ ДАРГА, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА,  
НЯГТЛАН БОДОГЧ НАР, АЙМГИЙН САНХҮҮ  
ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭСТ

Г Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний  
төсвийн болон төрийн өмчит аж ахуй нэгж,  
байгууллагуудын 2025 оны 04 дүгээр  
улирлын шилэн дансны мэдээлэлд  
хяналт шалгалт хийсэн тухай

### **1. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.”, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 8.5-т “Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.” гэсэн заалтууд, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын хүрээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

### **2. Шалгалтын зорилго**

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Сангийн сайдын гэрээ, Төрийн хяналт шалгалтын тухай, Төсвийн тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталж гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, үр дүнг аймгийн Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэх, мэдээлэл байршуулах эрх бүхий албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэн хийж гүйцэтгэсэн.

### **3. Шалгалтын зарчим, хамрах хүрээ**

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 09-ний

өдрийн 07/01 дүгээр удирдамжийн дагуу <https://gar.mof.gov.mn> дотоод аудитын хяналтын эрхэд бүртгэлтэй төсөвт байгууллага 162, Төвлөрүүлэн захирагч 20, Төрийн өмчит аж ахуй нэгж 8, нийт 190 байгууллага хамрагдсан. Тус 190 байгууллагаас түүвэрлэн цахим хуудсанд хяналт шалгалтыг дараах чиглэлээр хийж гүйцэтгэв.

3.1.Байгууллагын 2025 оны 04 дүгээр улирлын тайлан илгээлт

3.2.Төсөв, гүйцэтгэл

3.3.Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт

3.4.Бусад гэсэн 4 үндсэн бүлэгт багтаан мэдээллийг Шилэн дансны тухай хууль, холбогдох журмын дагуу үнэн зөв бодиттой, иж бүрэн, ойлгомжтой ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээллийг нээлттэй мэдээлсэн эсэхэд хяналт шалгалт хийсэн.

#### 4.Шалгалтын хэрэгжүүлэх хугацаа.

Удирдамжид заасан материалыг 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 01 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хүлээн авч, шалгалтыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 01 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд түүврийн арга ашиглан Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Бат-Эрдэнэ, Дотоод аудитор Ц.Энхжаргал нар хамтран хийж гүйцэтгэсэн.

#### 5.Шалгалтад хамрагдах асуудлууд.

5.1.Өмнөх улиралд хийсэн хяналт шалгалтаар өгсөн үүрэг, зөвлөмжийн биелэлт, түүний мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажилтай танилцаж биелэлтийг тооцох.

1.Баянхонгор аймгийн 190 төсвийн болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд 2025 онд нийт 34,602 мэдээллийг байршуулахаас 45 хувь буюу 15,678 мэдээллийг байршуулж 55 хувь буюу 18,924 мэдээлэлд байршуулах мэдээлэл байхгүй тул хоосон хадгалсан байна.

Шилэн дансны цахим системд мэдээлэл байршуулсан байдал

Хүснэгт 1

(Тоо)


№	Төрөл	Байгууллага тоо	Мэдээлэх нийт тоо	Оруулсан мэдээллийн тоо		Мэдээлэл оруулаагүй хоосон хадгалсан тоо	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
1	ТЭЗахирагч	20	3,596	2124	59%	1472	41%
2	Төсөвт байгууллага	162	29,646	13,171	44%	16,475	56%
3	ААНБайгууллага	8	1,360	383	28%	977	72%
Нийт дүн		190	34,602	15,678	45%	18,924	55%

Дээрх мэдээллээс харахад нийт байршуулах ёстой мэдээллийн 45 хувь нь шилэн дансны цахим системд мэдээлэл оруулсан бөгөөд бусад мэдээлэл нь байгууллагад тухай бүр гардаггүй мэдээллийг хоосон хадгалж байгаа нь харагдаж байна.

2.Төсөв байгууллагуудаас түүвэрлэн нийт 87 байгууллагаас олон нийтийн хандалтын судалгааг авахад 2025 онд нийт 21,252 иргэн шилэн дансанд мэдээлсэн мэдээлэлтэй танилцсан байна.


График 1

**Шилэн дансны олон нийтийн хандал**



3. Шилэн дансны цахим системийн мэдээллийн хяналтаар Баянхонгор аймаг 2025 онд нийт 174 байгууллагын 32,663 мэдээллийг байршуулахаас 30,283 мэдээлэл хугацаанд тайлагнаж, хугацаа хоцорсон 777 мэдээлэл, 2,380 мэдээллийг мэдээлээгүй гэж shilendans.gov.mn сайтад тайлагнасан байна.

Зураг 1



4. Төсөвт байгууллагууд шилэн дансны бие даасан цэстэй бөгөөд тус цахим системд мэдээллийг байршуулж, мэдээллийг тодруулах албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан ч байгууллагууд мэдээллийг 1, 2 дугаар гарын үсэг солигдох тухай бүрд мэдээллийг сольж ажиллаагүй зөрчил давтан гарсаар байна.

5. Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг Төрийн аудитын байгууллага, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар тухай бүр хяналт шалгалтыг хийж байгаа боловч, Аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал огт хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллахгүй байна.

6.Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний төсвийн болон төрийн өмчит аж ахуй нэгж, байгууллагуудын 2025 оны 3 дугаар улирлын шилэн дансны цахим хуудасны мэдээллийн 85.33 хувийг хуулийн хугацаанд хэрэгжүүлсэн байна. Нийт төсвийн 162, орон нутгийн өмчийн 8, төвлөрүүлэн захирагчийн 20, нийт 190 шилэн дансны цахим хуудас хяналт шалгалтад хамрагдсан.

**Байгууллагуудын 2025 оны 3 дугаар улирлын шилэн дансны цахим хуудсанд хяналт шалгалт хийсэн дүнгийн нэгтгэл**

Хүснэгт 2

(Тоо)

№	Үзүүлэлт	Төсөвт	Өмчит	Төвлөрүүлэн захирагч	Нийт	Гүйцэтгэл хувь
<b>Улирлын тайлан илгээсэн байдал</b>						
1	Хугацаандаа	138	6	14	158	83.16
2	Хоцорсон	7	-	4	11	5.79
3	Илгээгээгүй	17	2	2	21	11.05
	Нийт	162	8	20	190	100.00
	Гүйцэтгэл хувь	85.19	75.00	70.00	83.16	-
<b>Мэдээлэл байршуулсан байдал</b>						
1	Хугацаандаа	7,459	292	844	8,595	95.20
2	Хоцорсон	69	4	35	108	1.20
3	Байршуулаагүй	86	48	21	155	1.72
	Нийт	7,614	344	900	8,858	98.12
	Гүйцэтгэл хувь	97.96	84.88	93.78	97.03	-
<b>Хяналт шалгалтын материал ирүүлсэн байдал</b>						
1	Хугацаандаа	125	2	17	144	75.79
2	Хоцорсон	17	-	2	19	10.00
3	Ирүүлээгүй	20	6	1	27	14.21
	Нийт	162	8	20	190	100.00
	Гүйцэтгэл хувь	77.16	25.00	85.00	75.79	-

**5.2.Шилэн дансны тухай хууль болон Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын хэрэгжилт.**

Цахим тайлангийн хэрэгжилт.

1.Шилэн дансны цахим хуудасны 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар шилэн дансны 2025 оны 4 дүгээр улирлын тайланг нийт 167 байгууллага буюу 88 хувь нь хугацаандаа илгээж, 23 байгууллага буюу 12 хувь нь тайланг хуулийн хугацаанд илгээгээгүй байна.

**Байгууллагуудын 2025 оны 4 дүгээр улирлын тайлан илгээсэн байдал**

Хүснэгт 3

(Тоо)

№	Үзүүлэлт	Төсөвт	ААТҮГазар	Төвлөрүүлэн захирагч	Нийт	Гүйцэтгэл хувь
1	Хугацаандаа	144	6	17	167	88%
2	Хоцорсон	-	-	-	-	-
3	Илгээгээгүй	18	2	3	23	12%
4	Нийт	162	8	20	190	100%
5	Гүйцэтгэл хувь	89%	75%	85%	88%	-

(Тайланг хуулийн хугацаанд илгээгээгүй байгууллагын жагсаалтыг Хавсралт 1-т харуулав.)

Дээрх Шилэн дансны тайланг хугацаанд илгээгээгүй, нийт 23 байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т "Тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.1-т "Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь

байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

2.Шилэн дансны цахим хуудасны хяналт шалгалтад хамрагдаж буй 190 байгууллага нь 2025 оны 04 дүгээр улиралд нийт 7,956 мэдээлэл байршуулахаас 7,674 мэдээллийг хугацаандаа, 179 мэдээллийг хугацаа хоцроож, 103 мэдээллийг огт байршуулаагүй байна.

2025 оны 4 дүгээр улирлын мэдээлэл байршуулсан байдал

Хүснэгт 4

(Тоо)

№	Байгууллага	Хугацаандаа	Хоцорсон	Байршуулаагүй	Нийт	Гүйцэтгэлийн хувь
1	Төвлөрүүлэн захирагч	770	41	29	840	92%
2	ААТҮГазар	271	2	39	312	87%
3	Төсөвт байгууллага	6,633	136	35	6,804	97%
4	Нийт	7,674	179	103	7,956	96%
5	Гүйцэтгэлийн хувь	96.5%	2.3%	1.2%	100%	-

(Мэдээлэл оруулаагүй болон хугацаа хоцорч оруулсан байгууллагын жагсаалтыг Хавсралт 1-т харуулав)

Дээрх зөрчил нь Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэх зарчмыг алдагдуулсан байна.

3.Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний төсөвт байгууллагуудын 2025 оны 04 дүгээр улирлын Шилэн дансны цахим хуудасны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамжид заасан материалыг нийт 190 байгууллагаас 95 хувь буюу 182 байгууллага 2026 оны 01 дүгээр сарын 14-ний дотор ирүүлсэн. Нийт 8 байгууллага хяналт шалгалтад шаардлагатай материалыг хугацаанд ирүүлээгүй байгаа нь улирлын хяналт шалгалтад хүндрэл учруулж байна.

2025 оны 4 дүгээр улирлын удирдамжид заасан материалыг ирүүлсэн байдал

Хүснэгт 5

(Тоо)

№	Үзүүлэлт	Төсөвт	ААТҮГазар	Төвлөрүүлэн захирагч	Нийт	Гүйцэтгэл хувь
1	Хугацаандаа	156	6	20	182	95%
2	Хоцорсон	-	-	-	-	-
3	ирүүлээгүй	6	2	-	8	5%
4	Нийт	162	8	20	190	100%
5	Гүйцэтгэл хувь	85%	4%	11%	100%	-

(Материал ирүүлээгүй байгууллагын жагсаалтыг Хавсралт 1-т харуулав)

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйл 10.9.4-т “Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах.”, Санхүүгийн хяналт дотоод аудитын газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний төсөвт байгууллагуудын 04 дугаар улирлын Шилэн дансны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” 07/01 дүгээр удирдамжийн 6.2-т “Хяналт шалгалтад хамрагдах материалыг 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 18 цаг хүртэлх хугацаанд хүлээж авч заасан хугацаанд хяналт шалгалтад хамрагдаж материалыг ирүүлээгүй холбогдох албан тушаалтан нарт хариуцлага тооцох асуудлыг аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хуралд танилцуулан шийдвэрлэх”, 7.1-т “Хяналт шалгалтад шаардлагатай материалыг шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

### 5.3.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал

1.Төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга нарын 2025 оны 04 дүгээр улиралд өмч, хөрөнгө, мөнгөн гүйлгээтэй холбоотойгоор гаргасан шийдвэрийг 27 байгууллага нийт 106 тушаал, шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. (Тус байгууллагуудад улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.)

2.Шилэн дансны цахим хуудасны ерөнхий мэдээлэл хэсэгт нийт 29 байгууллагын дарга, нягтлан бодогчийн мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн байгааг залруулахаар Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.

Шилэн дансны цахим системд ерөнхий мэдээлэл зөрүүтэй байршуулсан байгууллагын жагсаалт

Хүснэгт 6

№	Мэдээлэл оруулаагүй байгууллагууд	№	Мэдээлэл оруулаагүй байгууллагууд
1	2	3	4
1	Баацагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	16	Жинст сумын Соёлын төв
2	Баянбулаг сумын Соёлын төв	17	Жинст сумын Хүүхдийн цэцэрлэг
3	Баянбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	18	Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
4	Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв	19	Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль
5	Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль	20	Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газар
6	Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар	21	Хүрээмарал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
7	Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг	22	Хүрээмарал сумын Хүүхдийн цэцэрлэг
8	Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг	23	Эрдэнэцогт сумын Соёлын төв
9	Шаргалжуут багийн Эрүүл мэндийн төв	24	Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв
10	Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар	25	Аймгийн Эрүүл мэндийн газар
11	Баянцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	26	Аймгийн Сум дундын ойн анги
12	Боловсролын газрын дэргэдэх насан туршийн боловсролын төв	27	Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ
13	Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв	28	Баян өсөх агро ОНӨААТҮГ
14	Галуут сумын Засаг даргын Тамгын газар	29	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац
15	Жинст сумын Ерөнхий боловсролын сургууль	-	-

3.Төвлөрүүлэн захирагчийн цэсэд шилэн дансны мэдээллийг байршуулж байгаа боловч Богд, Баянговь, Гурванбулаг, Жинст сумдын Орон нутгийн хөгжлийн сан, Гурванбулаг, Жинст сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн мэдээлэл байршуулах зориулалттай цэсийг Шилэн дансны цахим системд давхардуулан үүсгэсэн бөгөөд уг цэсэд мэдээлэл огт оруулаагүй, хоосон байдалтай байна.

4.Аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Эрүүл мэндийн газар, Насан туршийн боловсролын төвүүд нь төсвийн ерөнхийлөн захирагчийг зөрүүтэй сонгосноос тайланг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын хяналтын эрхэд илгээж байгаа бөгөөд ингэснээр тухайн байгууллагууд төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтад хамрагдахгүй, хяналт шалгалтад хамрагдах байх эрсдэлийг үүсгэж байна.

5.Баянхонгор аймгийн Биеийн тамир, спортын газар, Ерөнхий боловсролын Соого Сейкео сургууль, Шаргалжуут багийн ерөнхий боловсролын сургууль нь орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг боловч төсвийн ерөнхийлөн захирагчийг зөрүүтэй сонгосноос тайланг хяналтын эрхэнд илгээгдэхгүй байна.

6.“Баян өсөх агро” нь 2025 онд огт шилэн дансны мэдээллийг огт байршуулаагүй байна.

7. Шилэн дансны цахим сайтад нийт 33 байгууллага 72 мэдээллийг иж бүрэн оруулаагүй, хоосон байдлаар хадгалсан байна. (Тус байгууллагуудад улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.)

8. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний цэсэд 7 байгууллагын нийт 240,866,406 төгрөгийн орлогын гүйлгээ, 4 байгууллагын нийт 58,710,708 төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны цахим системд мэдээлээгүй орлого, зарлагын мөнгөн гүйлгээ

Хүснэгт 7

(төгрөг)

№	Сум байгууллагын нэр	Ирүүлсэн дансны хуулга, төсвийн хэлбэлзлээр			
		Өдөр цаг	Орлого	Зарлага	Гүйлгээний утга
1	Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх ХХК	12/25/2025	14,566,878	-	1200 айлыг цахилгаан
2		12/9/2025	6,322,260	-	ШШГГ төлбөр
3	Аймгийн Хөгжимт драмын театр	12/18/2025	42,410,100	-	Санхүүжилт
4	Баянхонгор сумын 16 дугаар цэцэрлэг	10/14/2025	21,587,000	-	Санхүүжилт
5		11/28/2025	8,572,600	-	Санхүүжилт
6		12/20/2025	7,144,500	-	Санхүүжилт
7	Баянхонгор сумын Баян-Ойт цэцэрлэг	12/17/2025	-	7,465,000	Бараа материалын үнэ
8	Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг	10/15/2025	10,150,500	-	Санхүүжилт
9		12/1/2025	9,464,000	-	Санхүүжилт
10		12/23/2025	-	11,144,456	Түлш халаалт
11	Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор	10/31/2025	10,000,000	-	Захирамж А/218
12	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	10/17/2025	-	15,000,000	Туршлага судлах уулзалтын зардал
13	Заг сумын Засаг даргын Тамгын газар	10/14/2025	-	10,000,000	Машины санхүүжилт
14	Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв	2025-12 сар	68,610,468	-	7 хоногийн дотор байршуулаагүй
15	Баянлиг сумын Хүүхдийн цэцэрлэг	11/28/2025	42,038,100	9,177,300	Халаалтын төлбөр
16	Баянлиг сумын Эрүүл мэндийн төв	11/30/2025	-	5,923,952	Халаалтын төлбөр
Нийт			240,866,406	58,710,708	-

9. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг цэсэд 5 байгууллагын нийт 113,472,711 төгрөгийн төсвийн гүйцэтгэлийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна.

Шилэн дансны цахим системд мэдээлээгүй худалдан авсан бараа, ажил үйлчилгээ

Хүснэгт 8

(төгрөг)

№	Байгууллагын нэр	Дансны хуулга, төсвийн хэлбэлзэл, байгуулсан гэрээгээр		
		Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр	Гүйлгээний өссөн дүнгээр	Гүйлгээ хийсэн огноо
1	2	3	4	5
1	Аймгийн Хөгжимт драмын театр	Материалын үнэ	6,000,000	2025-10-13
2		Тоног төхөөрөмжийн үнэ	13,500,000	2025-10-08
3		Материалын үнэ	9,406,500	2025-10-08
4		Мак гэрлийн үнэ	8,102,300	2025-10-09
5	Аймгийн Хүүхдийн театр	Тайз хувцасны зардал	10,519,500	2025-10-27
6		Эрүүл мэндийн үзлэгт хамруулах зардал	8,940,000	2025-10-27
7		Богино зайны станцын үнэ	6,400,000	2025-10-27
8	Заг сумын Засаг даргын Тамгын газар	Түлш, халаалт	6,199,776	2025-12-16

1	2	3	4	5
9	Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар	Гүний худаг гаруулсан төлбөр	20,000,000	2025-11-05
10		Хөв байгуулсан төлбөр	17,000,000	2025-11-05
11	Богд сумын Засаг даргын Тамгын газар	Түлш, халаалт	7,404,635	2025-12-22
<b>Нийт дүн</b>			<b>113,472,711</b>	

10. Байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлтийг тухай бүр 8 байгууллага нийт 28 тушаалаар бүтэц орон тоонд өөрчлөлт орсон байхад сар бүрийн мэдээлэлд өөрчлөлт оруулаагүй байна.

#### Бүтэц орон тоонд өөрчлөлт орсон тушаалын жагсаалт

#### Хүснэгт 9

№	Сум байгууллагын нэр	Ирүүлсэн тушаал шийдвэр		
		Огноо	Дугаар	Товч утга
1	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК	2025.11.03	Б/24	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
2	Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх ХХК	10/1/2025	Б/72	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
3		2025.10.28	Б/82	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
4	Чандмань Баянхонгор ХХК	2025.10.07	Б/141	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
5		2025.10.27	1/3/149	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
6		2025.10.30	1/3/150	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
7		2025.11.05	1/3/152	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
8		2025.11.05	1/3/155	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
9	Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг	2025.11.15	1/3/158	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
10		2025.12.05	Б/88	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
11		2025.12.22	Б/92	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
12		2025.10.01	Б/111	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
13	Гэгээн сумад сургууль, цэцэрлэгийн цогцолбор	2025.10.13	Б/113	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
14		2025.10.13	Б/114	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
15		2025.11.01	Б/124	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
16		2025.11.01	Б/129	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
17		2025.11.19	Б/131	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
18		2025.11.07	Б/133	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
19		2025.12.01	Б/138	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
20		2025.12.01	Б/139	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
21	Баян-Өндөр сумын ЗДТГ	11/14/2025	Б/36	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
22	Богд сумын Засаг даргын Тамгын газар	2025.12.10	3/2/Б/51	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
23		2025.10.30	3/2/Б/46	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
24		2025.10.01	3/2/Б/42	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
25	Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар	10/29/2025	Б/21	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
26		11/28/2025	Б/25	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
27		12/16/2025	Б/27	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон
28		12/16/2025	Б/28	Тушаалаар орон тооны өөрчлөлт орсон

11. Шилэн дансны цахимд системд байршуулж байгаа мэдээллийг зөвхөн нягтлан бодогч нар байршуулж байгаа боловч байгууллагын дарга нар хяналт тавьж ажилладаггүй, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг талаар тусгаагүй, үр дүнг тооцож ажилладаггүй байна.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” 7 дугаар зүйлийн 7.1-т “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ”, 7.1.1-т “Засгийн газрын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан

тушаалтан”, 7.1.3-т “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан”, 7.2-т “Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **5.4. Шилэн дансны тухай хуульд тулгамдаж байгаа асуудал**

1. Шилэн дансны тухай хууль нь төсөв, санхүүгийн мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох зорилготой боловч хэрэгжилтийн явцад дараах хүндрэл, зөрчил илэрч байна. Үүнд:

1.1. Олон нийтэд мэдээллийг нээлттэй байршуулж байгаа хэдий ч ойлгомжгүй, стандартгүй форматтай, бодит хүртээмж хангалтгүй.

1.2. Төсөв, санхүүтэй холбоотой ижил мэдээллийг Шилэн дансны цахим систем болон Шил ажиллагаа сайтад давхар гараар оруулж байгаа нь албан хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх, мэдээлэл давхардах нөхцөлийг бүрдүүлж байна.

1.3. Байршуулсан мэдээлэлд нэгтгэсэн тайлбар, дүн шинжилгээ дутмаг байгаа нь иргэдийн хяналт тавих боломжийг хязгаарлагдмал байна.

1.4. Олон нийтийн хандалт бодитоор хянах талаар хуульд нарийвчилсан зохицуулалт дутуу байна.

1.5. Шилэн дансны нэгдсэн системийн мэдээлэл байршуулах цэст нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хавсралтаас зөрүүтэй байгаа нь мэдээлэл байршуулж байгаа албан хаагч нарт ямар мэдээллийг аль хэсэгт байршуулах тодорхой бус байдлыг бий болгож байна.

#### **6. Дүгнэлт**

1. Баянхонгор аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний төсөвт болон төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын 2025 оны 4 дүгээр улирлын тайлан, Шилэн дансны цахим хуудасны үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар Шилэн дансны тухай хууль, журмыг хэрэгжилтэд анхаарч, мэдээллийн хуулийн хугацаанд, иж бүрэн, үнэн зөв мэдээлж ажиллах шаардлагатай гэж дүгнэв.

2. Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол болон <https://shilendans.gov.mn/> цахим сайтын хооронд уялдаа холбоо хангалтгүй байгаагаас олон нийтэд мэдээлж буй мэдээлэл ойлгомжгүй, давхардал ихтэй, иргэдийн бодит хандалтыг зөв тодорхойлох боломжгүй, бусад цахим системийн мэдээллийг давхардуулан байршуулж байгаа нь мэдээлэл оруулах албан хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж, хэрэгжилтэд хүндрэл бэрхшээл учруулж байгаа тул байгууллагын удирдлага болон мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнуудаас санал асуулга авч аймгийн Засаг дарга танилцуулан саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж ажиллах нь зүйтэй.

3. Хяналт шалгалтад хамрагдсан нийт 190 байгууллага нь шилэн дансны мэдээллийн 85.33 хувьтай хуулийн хугацаанд мэдээлсэн боловч үлдсэн 14.67 хувь нь хууль, дүрэм журамд заасан хугацаанд мэдээллийг байршуулаагүй зөрчил давтан гарсаар байна.

4.Шилэн дансны 2025 оны 04 дүгээр улирлын тайлан илгээлт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 23 байгууллага улирлын тайланг хугацаанд нь илгээгээгүй нь Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын тогтоолоор баталсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

5.Хяналт шалгалтаар байгууллагын удирдлага, нягтлан бодогчийн мэдээлэл зөрүүтэй оруулсан, шилэн дансны цахим хуудсыг давхардуулан үүсгэсэн боловч мэдээлэл огт байршуулаагүй, төсвийн ерөнхийлөн захирагчийг буруу сонгосны улмаас тайлан, хяналтын эрх зөрүүтэй тайлагнасан, Аймаг, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд төсөвт байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгаж үнэлж дүгнэж ажилладаггүй зэрэг зөрчил дутагдал илэрч байна.

6.Байгууллагын даргын тушаал шийдвэр, Бүтэц орон тоон өөрчлөл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлага, худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй, Мэдээллийг бүрэн оруулаагүй, хоосон хадгалсан зэрэг зөрчлүүд давтан гарсаар байна.

7.Шилэн дансны тухай хууль, холбогдох журам, стандартыг мөрдүүлэх, мэдээллийн үнэн зөв, бүрэн, хугацаанд нь байршуулах хариуцлагыг байгууллагын удирдлага болон мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнуудад тодорхой болгох, давтан илэрч буй зөрчлүүдэд хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

8.Хяналт шалгалтад шаардлагатай материалыг хугацаанд ирүүлээгүй, Шилэн дансны тухай хууль, холбогдох журам, удирдамжийн хэрэгжилтийг хангаагүй холбогдох байгууллагын удирдлага, мэдээлэл оруулах эрх бүхий албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудлыг Аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын хорооны хуралд танилцуулж, хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

#### **6.Цаашид авах арга хэмжээ**

Дараах арга хэмжээг цаг алдалгүй авч, Шилэн дансны зөрчлийг арилгах шаардлагатай.

#### **Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт:**

1.Төсөвт байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалтын зохион байгуулан Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэсэн заалтын хэрэгжүүлж ажиллах.

#### **Сумдын Засаг дарга нарт:**

1.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан, үр дүнг тооцож, ажилдаа хариуцлагагүй хандсан, мэдээллийг үнэн, иж бүрэн, хугацаанд байршуулаагүй байгууллагын дарга нарт хариуцлага тооцох асуудлын талаар хэлэлцэн шийдвэрлэж байх.

2.Байгууллагын дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлж дүгнэхдээ Шилэн дансны

тухай хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгон үзэж Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

**Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст:**

1.Шилэн дансны цахим хуудсанд байршуулж байгаа мэдээллийн үнэн зөв, иж бүрэн, хугацаандаа байршуулж байгаа эсэхэд тухай бүрд дотоод хяналт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр залруулж, тайлагнах тогтолцоог бий болгох.

2.Нягтлан бодогч нарын ажлыг үнэлж дүгнэхдээ Шилэн дансны цахим системд мэдээллийг үнэн зөв, иж бүрэн, тогтоосон хугацаанд байршуулсан байдалд үндэслэн үнэлж, хэрэгжилт хангалтгүй байгаа албан хаагчид нэмэгдэл хөлс олгохгүй байх асуудлыг төсөвт байгууллагын дарга нарт хүргүүлж ажиллах.

3.Шилэн дансны цахим системд давхардуулан үүсгэсэн Богд, Баянговь, Гурванбулаг, Жинст сумдын Орон нутгийн хөгжлийн сан, Гурванбулаг, Жинст сумдын Хоршоо хөгжүүлэх сан цахим цэстийг залруулж ажиллах.

4.Шилэн дансны мэдээллийг бүрэн, үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулах талаар байгууллагуудад сургалт, зааварчилгаа өгөх.

5.Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

**Байгууллагын дарга, нягтлан бодогч нарт:**

1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусган үр дүнг тооцож байх.



2.Шилэн дансны цахим системийн байгууллагын ерөнхий мэдээллийг шинэчлэн, Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлэх зарчмыг баримтлан хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.Шилэн дансны улирлын тайланг хугацаанд илгээж, хугацаа хоцроон илгээдэг байдлыг таслан зогсоох.

4.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дахин давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах.

5.Хяналтын шалгалтын удирдамжид тусгасан баримт материалын иж бүрэн хугацаанд ирүүлж хэвших.

ХЯНАСАН  
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Л.ЖАРГАЛЦЭЦЭГ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН  
ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН  
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ  Б.БАТ-ЭРДЭНЭ  
ДОТООД АУДИТОР  Ц.ЭНХЖАРГАЛ

Аймгийн засаг даргын эрхлэх хүрээний төсвийн болон төрийн  
өмчит аж ахуй нэгж, байгууллагуудын 2025 оны шилэн дансны  
цахим хуудсанд хийсэн хяналт шалгалтын дүнгийн нэгтгэл  
(Өссөн дүнгээр)

№	Байгууллагууд	Тайлан илгээх			Мэдээлэл байршуулалт			Материал ирүүлэх			Гүйцэтгэлийн хувь
		Хугацаандаа илгээсэн	Нийт илгээх тайлангийн тоо	Хувь	Хугацаандаа байршуулсан	Нийт байршуулах мэдээллийн тоо	Хувь	Хугацаандаа ирүүлсэн	Нийт материал ирүүлэх тоо	Хувь	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	ААН Баян өсөх агро ОНӨААТҮГ	0	4	-	1	170	0.59	1	4	25.00	8.53
2	ААН Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци	1	4	25.00	156	170	91.76	1	4	25.00	47.25
3	ААН Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх ХХК	1	4	25.00	162	170	95.29	3	4	75.00	65.10
4	ААН Жаргалтай амьдрал СНСЗЭТ	4	4	100.00	165	170	97.06	4	4	100.00	99.02
5	ААН Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ	4	4	100.00	170	170	100.00	1	4	25.00	75.00
6	ААН Сум дундын ойн анги	3	4	75.00	158	170	92.94	3	4	75.00	80.98
7	ААН Цэвэр хот ОНӨААТҮГ	4	4	100.00	165	170	97.06	3	4	75.00	90.69
8	ААН Чандмань Баянхонгор ХХК	4	4	100.00	168	170	98.82	4	4	100.00	99.61
9	Аймгийн Асрамжийн газар	2	4	50.00	182	183	99.45	0	4	-	49.82
10	Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	3	4	75.00	183	183	100.00	4	4	100.00	91.67
11	Аймгийн Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ	3	4	75.00	183	183	100.00	4	4	100.00	91.67
12	Аймгийн Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
13	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	175	183	95.63	4	4	100.00	98.54
14	Аймгийн Насан туршийн боловсролын төв	1	4	25.00	171	183	93.44	1	4	25.00	47.81
15	Аймгийн Нийтийн номын сан	4	4	100.00	181	183	98.91	3	4	75.00	91.30
16	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
17	Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
18	Аймгийн Соёл, урлагийн газар	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
19	Аймгийн Түүх угсаатны зүйн музей	3	4	75.00	179	183	97.81	2	4	50.00	74.27
20	Аймгийн Хөгжимт драмын театр	4	4	100.00	173	183	94.54	4	4	100.00	98.18
21	Аймгийн Худалдан авах ажиллагааны газар	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
22	Аймгийн Хүүхдийн театр	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
23	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
24	Аймгийн эрүүл мэндийн газар	3	4	75.00	183	183	100.00	1	4	25.00	66.67
25	Баацагаан сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
26	Баацагаан сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
27	Баацагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	4	75.00	178	183	97.27	4	4	100.00	90.76
28	Баацагаан сумын Соёлын төв	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
29	Баацагаан сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	175	181	96.69	4	4	100.00	98.90
30	Баацагаан сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
31	Баацагаан сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
32	Баянбулаг сумын ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
33	Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар	3	4	75.00	179	183	97.81	4	4	100.00	90.94
34	Баянбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	4	75.00	180	183	98.36	4	4	100.00	91.12
35	Баянбулаг сумын Соёлын төв	2	4	50.00	180	183	98.36	4	4	100.00	82.79
36	Баянбулаг сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	171	181	94.48	4	4	100.00	89.83
37	Баянбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
38	Баянбулаг сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
39	Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	178	183	97.27	3	4	75.00	90.76
40	Баянговь сумын Засаг даргын Тамгын газар	3	4	75.00	152	183	83.06	3	4	75.00	77.69
41	Баянговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	4	75.00	157	183	85.79	3	4	75.00	78.60
42	Баянговь сумын Соёлын төв	2	4	50.00	173	183	94.54	3	4	75.00	73.18
43	Баянговь сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	155	181	85.64	3	4	75.00	78.55
44	Баянговь сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	178	183	97.27	3	4	75.00	90.76
45	Баянговь сумын Эрүүл мэндийн төв	3	4	75.00	180	183	98.36	3	4	75.00	82.79
46	Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургууль	3	4	75.00	181	183	98.91	4	4	100.00	91.30
47	Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	180	183	98.36	3	4	75.00	91.12
48	Баянлиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	179	183	97.81	3	4	75.00	90.94
49	Баянлиг сумын Соёлын төв	3	4	75.00	183	183	100.00	4	4	100.00	91.67
50	Баянлиг сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	178	181	98.34	4	4	100.00	99.45
51	Баянлиг сумын Хүүхдийн цэцэрлэг	2	4	50.00	167	183	91.26	3	4	75.00	72.09
52	Баянлиг сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	179	183	97.81	4	4	100.00	99.27
53	Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль	3	4	75.00	181	183	98.91	3	4	75.00	82.97
54	Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
55	Баян-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
56	Баян-Овоо сумын Соёлын төв	2	4	50.00	121	183	66.12	4	4	100.00	72.04
57	Баян-Овоо сумын Төвлөрүүлэн захирагч	1	4	25.00	156	181	86.19	4	4	100.00	70.40
58	Баян-Овоо сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
59	Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв	3	4	75.00	182	183	99.45	4	4	100.00	91.48

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
60	Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль	3	4	75.00	183	183	100.00	4	4	100.00	91.67
61	Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар	2	4	50.00	179	183	97.81	4	4	100.00	82.60
62	Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	4	50.00	175	183	95.63	4	4	100.00	81.88
63	Баян-Өндөр сумын Соёлын төв	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
64	Баян-Өндөр сумын Төвлөрүүлэн захирагч	2	4	50.00	173	181	95.58	4	4	100.00	81.86
65	Баян-Өндөр сумын Хүүхдийн цэцэрлэг	3	4	75.00	183	183	100.00	4	4	100.00	91.67
66	Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төв	3	4	75.00	183	183	100.00	4	4	100.00	91.67
67	Баянхонгор сумын 1 Баян-Ойт Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
68	Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэг	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
69	Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэг	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
70	Баянхонгор сумын 12 дугаар цэцэрлэг	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
71	Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэг	4	4	100.00	166	183	90.71	4	4	100.00	96.90
72	Баянхонгор сумын 14 дүгээр цэцэрлэг	4	4	100.00	179	183	97.81	4	4	100.00	99.27
73	Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэг	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
74	Баянхонгор сумын 16 дугаар цэцэрлэг	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
75	Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэг	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
76	Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэг	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
77	Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэг	4	4	100.00	179	183	97.81	4	4	100.00	99.27
78	Баянхонгор сумын 5 дугаар цэцэрлэг	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
79	Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
80	Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг	4	4	100.00	176	183	96.17	4	4	100.00	98.72
81	Баянхонгор сумын 9 дүгээр цэцэрлэг	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
82	Баянхонгор сумын ЕР Баян-Ойт сургууль	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
83	Баянхонгор сумын ЕР Гэгээн сумади сургууль, цэцэрлэгийн цогцолбор	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
84	Баянхонгор сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
85	Баянхонгор сумын Ерөнхий боловсролын лаборатори номундалай цогцолбор сургууль	4	4	100.00	179	183	97.81	4	4	100.00	99.27
86	Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Номгон сургууль	3	4	75.00	181	183	98.91	4	4	100.00	91.30
87	Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Соого Сөйкөө сургууль	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
88	Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэм сургууль	4	4	100.00	178	183	97.27	4	4	100.00	99.09
89	Баянхонгор сумын Ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургууль	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
90	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
91	Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	172	183	93.99	4	4	100.00	98.00
92	Баянхонгор сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	179	181	98.90	4	4	100.00	99.63
93	Шаргалжуут багийн Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
94	Шаргалжуут багийн Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
95	Шаргалжуут багийн Эрүүл мэндийн төв	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
96	Баянхонгор сумын Шаргалжуут тосгон	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
97	Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	179	183	97.81	4	4	100.00	99.27
98	Баянцагаан сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	173	183	94.54	4	4	100.00	98.18
99	Баянцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	175	183	95.63	4	4	100.00	98.54
100	Баянцагаан сумын Соёлын төв	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
101	Баянцагаан сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	174	181	96.13	4	4	100.00	98.71
102	Баянцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
103	Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	178	183	97.27	4	4	100.00	99.09
104	Богд сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
105	Богд сумын Засаг даргын Тамгын газар	3	4	75.00	176	183	96.17	4	4	100.00	90.39
106	Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	4	25.00	176	183	96.17	4	4	100.00	73.72
107	Богд сумын Соёлын төв	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
108	Богд сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	166	181	91.71	4	4	100.00	97.24
109	Богд сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
110	Богд сумын Эрүүл мэндийн төв	3	4	75.00	180	183	98.36	4	4	100.00	91.12
111	Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	181	183	98.91	3	4	75.00	91.30
112	Бөмбөгөр сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	174	183	95.08	3	4	75.00	90.03
113	Бөмбөгөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	175	183	95.63	2	4	50.00	81.88
114	Бөмбөгөр сумын Соёлын төв	4	4	100.00	182	183	99.45	3	4	75.00	91.48
115	Бөмбөгөр сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	180	181	99.45	4	4	100.00	99.82
116	Бөмбөгөр сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	180	183	98.36	3	4	75.00	91.12
117	Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв	2	4	50.00	176	183	96.17	2	4	50.00	65.39
118	Бууцагаан сумын Баянбүрд багийн Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
119	Бууцагаан сумын баянбүрд багийн Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
120	Бууцагаан сумын ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
121	Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	178	183	97.27	4	4	100.00	99.09
122	Бууцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	178	183	97.27	4	4	100.00	99.09
123	Бууцагаан сумын Соёлын төв	4	4	100.00	177	183	96.72	4	4	100.00	98.91
124	Бууцагаан сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	173	181	95.58	4	4	100.00	98.53
125	Бууцагаан сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
126	Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
127	Галуут сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	180	183	98.36	3	4	75.00	91.12
128	Галуут сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	176	183	96.17	3	4	75.00	90.39
129	Галуут сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4	4	100.00	178	183	97.27	3	4	75.00	90.76
130	Галуут сумын Мандал бага сургууль	4	4	100.00	181	183	98.91	3	4	75.00	91.30
131	Галуут сумын Соёлын төв	4	4	100.00	176	183	96.17	3	4	75.00	90.39
132	Галуут сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	178	181	98.34	3	4	75.00	91.11
133	Галуут сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	180	183	98.36	3	4	75.00	91.12
134	Галуут сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	179	183	97.81	3	4	75.00	90.94
135	Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
136	Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
137	Гурванбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	179	183	97.81	4	4	100.00	99.27
138	Гурванбулаг сумын Соёлын төв	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
139	Гурванбулаг сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	177	181	97.79	4	4	100.00	90.93
140	Гурванбулаг сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	178	183	97.27	4	4	100.00	99.09
141	Гурванбулаг сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
142	Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	176	183	96.17	3	4	75.00	90.39
143	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	3	4	75.00	174	183	95.08	4	4	100.00	90.03
144	Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	4	50.00	175	183	95.63	4	4	100.00	81.88
145	Жаргалант сумын Соёлын төв	4	4	100.00	177	183	96.72	3	4	75.00	90.57
146	Жаргалант сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	162	181	89.50	4	4	100.00	88.17
147	Жаргалант сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	179	183	97.81	3	4	75.00	90.94
148	Жаргалант сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	180	183	98.36	3	4	75.00	91.12
149	Жинст сумын Ерөнхий боловсролын сургууль	1	4	25.00	178	183	97.27	4	4	100.00	74.09
150	Жинст сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
151	Жинст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	183	183	100.00	4	4	100.00	100.00
152	Жинст сумын Соёлын төв	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
153	Жинст сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	168	181	92.82	4	4	100.00	89.27
154	Жинст сумын Хүүхдийн цэцэрлэг	1	4	25.00	180	183	98.36	4	4	100.00	74.45
155	Жинст сумын Эрүүл мэндийн төв	3	4	75.00	178	183	97.27	4	4	100.00	90.76
156	Заг сумын Ерөнхий боловсролын сургууль	2	4	50.00	181	183	98.91	4	4	100.00	82.97
157	Заг сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
158	Заг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
159	Заг сумын Соёлын төв	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
160	Заг сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	179	181	98.90	4	4	100.00	91.30
161	Заг сумын Хүүхдийн цэцэрлэг	2	4	50.00	179	183	97.81	4	4	100.00	82.60
162	Заг сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	178	183	97.27	4	4	100.00	99.09
163	Өлзийт сумын Ерөнхий боловсролын сургууль	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
164	Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
165	Өлзийт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
166	Өлзийт сумын Соёлын төв	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
167	Өлзийт сумын Төвлөрүүлэн захирагч	4	4	100.00	179	181	98.90	4	4	100.00	99.63
168	Өлзийт сумын Хүүхдийн цэцэрлэг	4	4	100.00	181	183	98.91	4	4	100.00	99.64
169	Өлзийт сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	180	183	98.36	4	4	100.00	99.45
170	Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль	3	4	75.00	178	183	97.27	2	4	50.00	74.09
171	Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газар	4	4	100.00	181	183	98.91	2	4	50.00	82.97
172	Хүрээмарал сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	4	75.00	179	183	97.81	2	4	50.00	74.27
173	Хүрээмарал сумын Соёлын төв	4	4	100.00	183	183	100.00	3	4	75.00	91.67
174	Хүрээмарал сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	172	181	95.03	3	4	75.00	81.68
175	Хүрээмарал сумын Хүүхдийн цэцэрлэг	3	4	75.00	178	183	97.27	2	4	50.00	74.09
176	Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв	4	4	100.00	182	183	99.45	4	4	100.00	99.82
177	Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль	2	4	50.00	149	183	81.42	1	4	25.00	52.14
178	Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газар	3	4	75.00	175	183	95.63	2	4	50.00	73.54
179	Шинэжинст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	4	75.00	176	183	96.17	3	4	75.00	82.06
180	Шинэжинст сумын Соёлын төв	3	4	75.00	176	183	96.17	2	4	50.00	73.72
181	Шинэжинст сумын Төвлөрүүлэн захирагч	3	4	75.00	154	181	85.08	3	4	75.00	78.36
182	Шинэжинст сумын Хүүхдийн цэцэрлэг	2	4	50.00	148	183	80.87	1	4	25.00	51.96
183	Шинэжинст сумын Эрүүл мэндийн төв	3	4	75.00	173	183	94.54	1	4	25.00	64.85
184	Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль	3	4	75.00	181	183	98.91	3	4	75.00	82.97
185	Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар	3	4	75.00	176	183	96.17	2	4	50.00	73.72
186	Эрдэнэцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3	4	75.00	175	183	95.63	2	4	50.00	73.54
187	Эрдэнэцогт сумын Соёлын төв	2	4	50.00	175	183	95.63	2	4	50.00	65.21
188	Эрдэнэцогт сумын Төвлөрүүлэн захирагч	0	4	-	135	181	74.59	2	4	50.00	41.53
189	Эрдэнэцогт сумын Хүүхдийн цэцэрлэг	3	4	75.00	181	183	98.91	3	4	75.00	82.97
190	Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв	3	4	75.00	183	183	100.00	3	4	75.00	83.33
	Нийт	658	760	86.58	33447	34626	96.60	668	760	87.89	90.36